



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,  
Утас/факс: (976-11) 329084  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2013. 09. 20 № 1/3623

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


Г УЛСЫН ИХ ХУРЛЫН Г  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА  
Ш.ТҮВДЭНДОРЖ ТАНАА

Банк бус санхүүгийн байгууллагуудын 2013 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулгыг хураангуй тайлан тэнцэл болон орлого үр дүнгийн тайлангийн хамт хүргүүлж байна.

Хавсралт <sup>25</sup>... хуудас.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН

001543

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН  
2013 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2013.9.10

Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

2013 оны эхний хагас жилд Хорооны хуралдаанаар 21 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 22 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 1 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 233 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрлөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тооны өөрчлөлтийг графикаар үзүүлбэл:

/График 1/



Тайлант хугацаанд Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

/Хүснэгт 1/

№		Тайлант хугацаа		
		2012 оны эхний хагас жилд	2013 оны эхний хагас жилд	өөрчлөлт
1	Тусгай зөвшөөрлийг сунгасан	35	19	-16
2	Тусгай зөвшөөрөл шинээр олгосон	8	22	+14
3	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	5	1	-4
4	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	4	-	-4
5	Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	1	-	-1
6	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	198	233	+35

ББСБ-уудын нийт тоо болон орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тооны өөрчлөлтийг харуулбал:

/Хүснэгт 2/

№	Тайлант хугацаа	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	Үүнээс:		
			Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ
1	2008 он	132	23	11	-

2	2009 он	177	27	9	47
3	2010 он	182	26	15	48
4	2011он	195	23	17	39
5	2012 он	212	24	18	38
6	2013.I улирал	229	25	18	39
7	2013.II улирал	233	25	18	39

2013 оны эхний хагас жилд Баянхонгор аймагт 2 ББСБ тус бүр 50.0 сая төгрөгөөр дүрмийн санг бүрдүүлж зээлийн үйл ажиллагаа, Улаанбаатар хотод 20 ББСБ 100.0-600.0 сая төгрөгийн дүрмийн сантайгаар зээл, гадаад валютын арилжаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна.

2013 оны эхний хагас жилд банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн тохиолдол байхгүй байна.

ББСБ-уудыг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 3/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо		
		2012 оны эхний хагас жилд	2013 оны эхний хагас жилд	
1	Зээл	171	191	
2	Факторингийн үйлчилгээ	12	13	
3	Төлбөрийн баталгаа гаргах	8	9	
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	-	-	
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	5	
6	Гадаад валютын арилжаа:	Давхар эрхэлдэг	94	98
		Дагнан эрхэлдэг	38	39
7	Итгэлцлийн үйлчилгээ	18	18	
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2	
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	18	19	
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	-	
11	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ <sup>1</sup> /Венчур хөрөнгө оруулалт/	1	-	

2012 оны жилийн эцэст банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 212 ББСБ-уудаас 80.7 хувь нь зээл, 44.3 хувь нь гадаад валютын арилжаа, 8.5 хувь нь хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэн явуулж байсан бол 2013 оны эхний хагас жилийн байдлаар 22 ББСБ шинээр үүсгэн байгуулагдан, 1 ББСБ хүчингүй болсноор нийт тусгай зөвшөөрөлтэй 233 ББСБ-ын 82.0 хувь нь зээл, 42.1 хувь нь гадаад валютын арилжаа /16.7 хувь нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг/, 8.1 хувь нь хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 2.1 хувь нь цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 5.6 хувь нь факторингийн үйлчилгээ, 3.9 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 7.7 хувь нь итгэлцлийн үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна.

2013 оны эхний хагас жилийн байдлаар тайлан ирүүлбэл зохих нийт 233 ББСБ-аас 231 ББСБ тайлангаа ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн хариуг хүргүүлсэн.

<sup>1</sup>Банк бус санхүүгийн үйл ажиллагааны хуульд заагдсан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамаарахгүй бөгөөд Хорооны 2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх түр журам"-ыг баталсан.

## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Ерөнхий статистик үзүүлэлтүүд:

Өмнөх оны жилийн эцсийн голлох статистик үзүүлэлтүүдийг 2013 оны эхний хагас жилийн тайлант хугацааны байдалтай харуулбал: Үүнд

/Хүснэгт 4/


№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны жилийн эцэст	2013 оны эхний хагас жилд	Өсөлт +/, бууралт -/
1	ББСБ-ын тоо	212	233	+21
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	599	617	+18
3	Ажиллагсадын тоо	1,193	1,292	-99
4	Салбар нэгжийн тоо	69	74	+5
5	Харилцагчдын тоо	483,015	394,666	-88,349
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	252,053,541.4	307,736,217.0	55,682,675.6
<b>Банкны салбарт эзлэх хувь</b>		<b>2.10%</b>	<b>1.93%</b>	<b>-0.17%</b>
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	157,769,345.8	188,120,936.3	30,351,590.5
<b>Банкны салбарт эзлэх хувь</b>		<b>2.24%</b>	<b>2.17%</b>	<b>-0.07%</b>
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	171,296,659.6	198,714,723.9	27,418,064.3
<b>Банкны салбарт эзлэх хувь</b>		<b>17.38%</b>	<b>17.43%</b>	<b>0.05%</b>
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	139,194,226.2	160,984,853.6	21,790,627.4
<b>Банкны салбарт эзлэх хувь</b>		<b>44.94%</b>	<b>44.98%</b>	<b>0.04%</b>
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	14,111,454.9	17,852,496.9	+3,741,042.0
11	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	46,142,177.6	63,522,781.9	+17,380,604.3
	Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/	25,469,545.7	42,860,936.8	17,391,391.1
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	20,672,631.9	20,661,845.2	- 10,786.7
12	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	7,977,378.4	9,559,052.2	+1,581,673.8
13	Нийт орлого /мянган төгрөгөөр/	116,157,189.5	37,965,607.3	-
14	Нийт зардал /мянган төгрөгөөр/	51,903,731.8	25,002,368.6	-
15	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	18,579,379.1	12,963,238.7	- 5,616,140.4

2013 оны эхний хагас жилийн байдлаар ББСБ-ын нийт актив оны эхнээс 22.1 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд дүрмийн сан 21.8 тэрбум төгрөгөөр буюу тухайлвал тайлан жилд шинээр тусгай зөвшөөрөл авсан 22 ББСБ-ын нийт дүрмийн сан 7.3 тэрбум төгрөг, өмнө нь тусгай зөвшөөрөлтэй байсан 61 ББСБ-ууд нийт 13.2 тэрбум төгрөгөөр дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулсан буюу нэмэлт хөрөнгө оруулалт, хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн.

2013 оны эхний хагас жилийн байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэй 233 ББСБ байгаагийн 89.3 хувь буюу 208 ББСБ нь УБ хотод, 10.7 хувь буюу 25 ББСБ нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

ББСБ-уудын байршлыг графикаар үзүүлбэл:

/график 2/



## 2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2013 оны эхний хагас жилийн байдлаар орон нутагт төвтэй 25 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 10.7 хувийг, тэдгээрийн актив нь нийт ББСБ-ын активын 2.1 хувийг, олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын 2.8 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 3.0 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 2.7 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

		/Хүснэгт 5/		
№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны жилийн эцэс	2013 оны эхний хагас жилд	Өсөлт /+/, бууралт /-/
Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо		24	25	1
<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>		<b>12.12%</b>	<b>10.73%</b>	<b>-1.39%</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	6,254,321.4	6,593,823.0	339,501.6
<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>		<b>2.48%</b>	<b>2.14%</b>	<b>0.34%</b>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	4,802,425.5	5,212,788.6	410,363.1
<b>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</b>		<b>3.04%</b>	<b>2.77%</b>	<b>-0.27%</b>
	Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	111,512.1	141,457.9	29,945.8
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	5,655,029.6	6,034,670.2	379,640.6
<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>		<b>3.30%</b>	<b>3.04%</b>	<b>-0.26%</b>
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	4,434,871.2	4,420,761.8	-14,109.4
<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>		<b>3.19%</b>	<b>2.75%</b>	<b>-0.44%</b>
Д	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	164,555.6	6,385.6	158,170.0
	Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/	-	-	-
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	164,555.6	6,385.6	158,170.0
Е	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	134,999.7	104,999.7	30,000.0
Ё	Нийт орлого /мянган төгрөгөөр/	1,429,326.0	870,301.6	-
Ж	Нийт зардал /мянган төгрөгөөр/	665,603.05	418,604.2	-
З	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	763,722.9	451,697.4	-

Хорооноос орон нутагт бичил санхүүгийн тоог нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээний

дүрмийн сангийн доод хэмжээг ялгавартай тогтоосон хэдий ч дорвитой өсөлт гарахгүй байгаа нь орон нутагт бичил санхүүгийн үйлчилгээний ач тусын талаар ойлголт муу буюу санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээлэл, сурталчилгаа байхгүй байгаатай холбоотой байна.

### **2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:**

2013 оны эхний хагас жилийн байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 18 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 7.7 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 15.6 хувийг, олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 16.8 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн 15.3 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 15.1 хувийг тус тус эзэлж байна.

/Хүснэгт 6/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны жилийн эцэст	2013 оны эхний хагас жилд	Өсөлт /+/, бууралт /-/
	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	17	18	+1
	<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>	<b>8.49%</b>	<b>7.73%</b>	<b>-0.76%</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	44,357,733.6	48,018,726.0	3,660,992.40
	<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>	<b>17.60%</b>	<b>15.60%</b>	<b>-2.0%</b>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	29,287,989.7	31,668,633.6	2,380,643.90
	Үүнээс: Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	2,077,091.0	2,451,069.3	373,978.30
	<b>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</b>	<b>18.56%</b>	<b>16.83%</b>	<b>-1.73%</b>
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	29,658,596.3	30,445,059.91	786,463.61
	<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>	<b>17.31%</b>	<b>15.32%</b>	<b>-1.99%</b>
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	23,698,562.5	24,300,362.5	601,800.00
	<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>	<b>17.19%</b>	<b>15.09%</b>	<b>0.95%</b>
Д	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	9,981,488.9	12,320,723.2	2,339,234.30
	Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/	6,260,651.1	8,637,850.3	2,377,199.20
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	3,720,837.8	3,682,872.9	37,964.90
Е	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	248,890.6	425,000.0	176,109.40
Ё	Нийт орлого /мянган төгрөгөөр/	11,078,371.0	6,347,187.8	-
Ж	Нийт зардал /мянган төгрөгөөр/	9,233,42.6	5,080,513.2	-
З	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	1,845,328.4	1,266,674.7	-578,653.70

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 10, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 4, Итали, ОХУ, АНУ, БНХАУ-ын хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

2013 оны эхний хагас жилийн байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдоогүй бөгөөд энэ нь Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хууль батлагдсанаар гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход Улсын Их Хурал, Засгийн газраас хэлцэл хийх зөвшөөрөл олгосны эцэст шийдвэрлэхээр заасантай холбоотой юм.

2013 оны эхний хагас жилийн байдлаар Хороонд тусгай зөвшөөрөл хүссэн нэр бүхий 4 аж ахуйн нэгжийн хүсэлт ирснээс Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 193 тоот тогтоолоор “Нихон капитал фаяннс” ХХК-д хэлцэл хийх зөвшөөрөл олгогдсон бөгөөд өнөөдрийн байдлаар Хороонд хянагдаж байна.

### **2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ:**

Тайлант хугацаанд буюу 2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт 22 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосноос 18.2 хувь буюу 4

ББСБ-д банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 233 ББСБ байгаагийн 98 ББСБ буюу 42.1 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагийн дотор 39 ББСБ нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Гадаад валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 39 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 16.7 хувийг, тэдгээрийн актив нийт ББСБ-ын активын 2.6 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 4.0 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 4.1 хувийг тус тус эзэлж байна.

/Хүснэгт 7/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны жилийн эцэст	2013 оны эхний хагас жилд	Өсөлт +/-, бууралт +/-
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	38	39	1
	<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>	<b>17.92%</b>	16.74%	-1.18%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	8,105,754.72	8,029,948.00	75,806.72
	<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>	<b>3.21%</b>	2.61%	-0.6
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	7,547,276.99	7,895,104.15	347,827.16
	<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>	<b>4.40%</b>	3.97%	-0.43%
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	6,281,692.37	6,678,692.37	397,000.0
	<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>	<b>4.51%</b>	4.15%	-0.36%
Г	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	9,981,488.90	-	-
Д	Нийт орлого /мянган төгрөгөөр/	8,688,029.3	-	-
Е	Нийт зардал /мянган төгрөгөөр/	8,136,914.4	-	-
Ё	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	551,114.9	-	-

## ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 3.1 Активын бүтэц, өөрчлөлт:

Тайлант хугацаанд нийт ББСБ-уудын активын бүтэц өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд: /мянган төгрөгөөр/

/Хүснэгт 8/

№	ХӨРӨНГӨ	2012.6.30		2013.6.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>А</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>221,252,605.2</b>	<b>96.7%</b>	<b>297,169,765.80</b>	<b>96.57%</b>	<b>75,917,160.60</b>	<b>34.3%</b>
1	Мөнгөн хөрөнгө	69,456,006.1	30.4%	83,203,677.83	27.04%	13,747,671.73	19.8%
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	2,160,430.9	0.9%	9,359,030.14	3.04%	7,198,599.24	4.3 дахин
3	Нийт зээл	139,158,864.5	60.8%	188,120,936.31	61.13%	48,962,071.81	35.2%
	(Зээлийн эрсдлийн сан)	4,145,108.3	1.8%	5,127,631.05	1.67%	982,522.75	23.7%
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	619,573.2	0.3%	1,317.28	0.11%	-618,255.92	-99.8%
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	0.0	0.0%	0	-	0.00	0.0%
5	Нийт факторингийн тооцооны авлага	940,035.0	0.4%	842,431.93	0.27%	-97,603.07	-10.4%
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	0.0	0.0%	0	-	0.00	0.0%
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	809,844.6	0.4%	835,501.96	0.27%	25,657.36	3.2%
7	Бусад хөрөнгө	12,166,472.6	5.3%	19,934,501.40	6.48%	7,768,028.80	63.8%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага	0.0	0.0%	0	-	0.00	0.0%
<b>Б</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>7,569,657.6</b>	<b>3.3%</b>	<b>10,566,449.55</b>	<b>3.43%</b>	<b>2,996,791.95</b>	<b>39.6%</b>

9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	7,569,657.6	3.3%	10,566,449.55	3.43%	2,996,791.95	39.6%
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	9,992,444.5	4.4%	13,837,284.14	4.50%	3,844,839.64	38.5%
	(Хуримтлагдсан элэгдэл)	2,422,786.9	1.1%	3,270,834.58	1.06%	848,047.68	35.0%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>228,822,262.8</b>	<b>100.0%</b>	<b>307,736,217.00</b>	<b>100.00%</b>	<b>78,913,954.20</b>	<b>34.5%</b>

2013 оны эхний хагас жилийн байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 233 компани нь 307,736,217.0 мянган төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа ба активын өсөлт нь 2012 оны жилийн эцсийн байдлаас 55,682,675.6 мянган төгрөгөөр буюу 22.1 хувиар, өмнөх оны тайлант үетэй харьцуулахад 78,913,954.20 мянган төгрөгөөр буюу 34.5 хувиар тус тус өссөн байна.

Тайлант хугацаанд нийт активын 96.6 хувь нь эргэлтийн хөрөнгө, 3.4 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна.


Активын өсөлтийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/график 3/



ББСБ-уудын нийт активын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 4/





**3.2 Зээлийн багцын чанар:**

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.


/Хүснэгт 9/

№	Ангилал	2012.6.30		2013.6.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	Хэвийн	129,907,793.4	93.4%	74,134,797.76	92.57%	44,227,004.36	34.04%
2	Хугацаа хэтэрсэн	3,754,086.3	2.7%	6,827,944.89	3.63%	3,073,858.59	81.88%
3	Чанаргүй зээл. Үүнээс	5,496,984.8	4.0%	7,158,193.65	3.81%	1,661,208.85	30.22%
	Хэвийн бус	1,397,278.2	1.0%	1,916,206.22	1.02%	518,928.02	37.14%
	Эргэлзээтэй	921,373.0	0.7%	1,933,264.75	1.03%	1,011,891.75	2.1 дахин
	Муу	3,178,333.6	2.3%	3,308,722.68	1.76%	130,389.08	4.10%
	(Зээлийн эрсдлийн сан)	4,145,108.3	3.0%	5,127,631.05	2.73%	982,522.75	23.70%
	Нийт зээл	139,158,864.5	100.0%	188,120,936.30	100.00%	48,962,071.80	35.18%

2013 оны эхний хагас жилийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багц 35.2 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 34.0 хувиар, хугацаа хэтэрсэн зээл 81.9 хувиар, чанаргүй зээл 30.2 хувиар тус тус өссөн хэдий боловч зээлийн чанарт төдийлөн ахиц гараагүй байна гэж үзэж байна.

ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал:

/График 5/



Графикаас харахад нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 2009 онд хамгийн өндөр үзүүлэлттэй буюу 8.8 хувьтай байсан бөгөөд тайлант 2013 оны эхний хагас жилийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төдийлөн ахиц гараагүй байна.

**3.3 Зээлийн хүү:**

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 233 ББСБ-аас 82.0 хувь буюу 191 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын зээлийн сарын хамгийн дээд хүү 8.0 хувь, хамгийн бага хүү 0.5 хувь байна.

ББСБ-уудын зээлийн сарын дундаж дээд хүү 4.7 хувь, зээлийн дундаж доод хүү 2.7 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 3.7 хувь байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.

/График 6/



**Активын бусад үзүүлэлтийн талаар:**

Санхүүгийн түрээсийн тооцооны авлага 1,317.3 мянган төгрөг /Эрхэс-Эрдэнэ ББСБ, Хамона ББСБ, Баян-Эрдэнэ цогт ББСБ, Тунамал алтан зоос ББСБ-д бүртгэгдсэн/, факторингийн тооцооны авлага 842,431.9 мянган төгрөг /Монгол факторинг ББСБ, Дошт Даймонд ББСБ / бүртгэгдсэн байна.

2013 оны 01 дүгээр улирлаас эхлэн ББСБ-аас ирүүлж буй зохистой харьцааны тайланд шинээр нэмж тухайн улиралд олгосон зээл, эргэн төлөлтийн талаарх судалгаа, мөн оны 02 дугаар улирлын тайланд гадаадын даатгалын байгууллагад даатгагдсан эсэх талаарх судалгаануудыг авч эхэлсэн.

Дээрх олгосон зээл, эргэн төлөлтийн талаарх судалгаанд зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг нийт 191 ББСБ-аас 145 ББСБ нь буюу 75.9 хувь нь хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан ББСБ-уудад тайлант хугацаанд 112,479.3 сая төгрөгийн зээл олгож, 93,208.1 сая төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна. Олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 4.1 хувьтай байна.

Харин тайлант хугацаанд тайлан ирүүлбэл зохих нийт 233 ББСБ-аас 231 ББСБ тайлангаа ирүүлсний дотор гадаадын даатгалын байгууллагад даатгагдсан ББСБ байхгүй байна.

**ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ**

ББСБ-уудын 2013 оны эхний хагас жилийн байдлаарх нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 10/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2012.6.30		2013.6.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	<b>Өр төлбөр</b>	<b>67,756,365.8</b>	<b>29.6%</b>	<b>92,967,283.2</b>	<b>30.2%</b>	<b>25,210,917.4</b>	<b>37.2%</b>
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	13,626,666.7	6.0%	17,852,497.0	5.8%	4,225,830.3	31.0%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	45,234,037.6	19.8%	63,522,781.9	20.6%	18,288,744.3	40.4%
3	Бусад эх үүсвэр	3,392,371.4	1.5%	1,656,119.6	0.5%	-1,736,251.8	-51.2%
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	-	-	-	-	-	-
	Монгол гуйвуулгын үйлчилгээний өглөг	3,358,559.6	1.5%	1,656,119.6	0.5%	-1,702,440.0	-50.7%
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	33,811.8	0.0%	-	-	-33,811.8	-100.0%
	Факторингийн үйлчилгээний өглөг	-	-	-	-	-	-

	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	-	-	-	-
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	-	-	376,832.5	0.1%	376,832.5	100.0%
5	Төслийн зээлийн санхүүжилт	5,503,290.2	2.4%	9,559,052.2	3.1%	4,055,762.0	73.7%
<b>Б</b>	<b>Бусад өр төлбөр</b>	<b>8,489,934.1</b>	<b>3.7%</b>	<b>16,054,208.2</b>	<b>5.2%</b>	<b>7,564,274.2</b>	<b>89.1%</b>
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,253,697.3	1.0%	2,545,833.2	0.8%	292,135.9	13.0%
7	Бусад пассив	6,236,236.9	2.7%	13,506,723.8	4.4%	7,270,486.9	2.1 дахин
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	-	-	1,651.3	0.0	1,651.3	100.0%
	<b>Нийт өр төлбөр</b>	<b>76,246,300.0</b>	<b>33.3%</b>	<b>109,021,491.4</b>	<b>35.4%</b>	<b>32,775,191.4</b>	<b>43.0%</b>
<b>Б</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>152,575,962.8</b>	<b>66.7%</b>	<b>198,714,723.9</b>	<b>64.6%</b>	<b>46,138,761.1</b>	<b>30.2%</b>
9	Хувьцаат капитал	129,215,227.1	56.5%	160,984,853.6	52.3%	31,769,626.5	24.6%
10	Бусад өмч	3,202,901.3	1.4%	6,573,384.5	2.1%	3,370,483.2	2.0 дахин
11	Сангууд	1,245,771.5	0.5%	187,258.4	0.1%	-1,058,513.1	-85.0%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	16,352,011.3	7.1%	29,146,594.2	9.5%	12,794,582.9	78.2%
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	2,560,051.6	1.1%	1,822,633.2	0.6%	-737,418.4	-28.8%
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>228,822,262.8</b>	<b>100.0%</b>	<b>307,736,217.0</b>	<b>100.0%</b>	<b>78,913,954.2</b>	<b>34.5%</b>

2012 оны жилийн эцсийн тайлангаар нийт эх үүсвэрийн 32.0 хувийг нийт өр төлбөр, 68.0 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт өр төлбөр 35.4 хувь, эзэмшигчийн өмч 64.6 хувь болж өөрчлөгдсөн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 43.0 хувиар, эзэмшигчдийн өмч 30.2 хувиар тус тус өссөн байна.


2013 оны эхний хагас жилд нийт эх үүсвэрт эзлэх өр төлбөр өссөн гол шалтгаан нь ББСБ-уудын дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл 63,522.8 сая төгрөгт хүрч өмнөх оноос 40.4 хувиар буюу 18,288.7 сая төгрөгөөр, итгэлцлийн үйлчилгээний өглөг 17,852.5 сая төгрөгт хүрч өмнөх оноос 31.0 хувиар буюу 4,225.8 сая төгрөгөөр, бусад пассив 13,506.7 сая төгрөгт хүрч өмнөх оноос 2.1 дахин буюу 7,270.5 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.


Мөн банк бус санхүүгийн байгууллага шинээр нэмэгдэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдсэнтэйгээр дүрмийн сан өсч байна.

ББСБ-уудын системийн нийт пассивын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 7/



/График 8/



2013 оны эхний хагас жилийн байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 18 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 7.7 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 36.3 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 31.5 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд тайлант хугацаанд 17,852,496.96 мянган төгрөгийн итгэлцлийн үйлчилгээний өглөг бүртгэгдсэн байна.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 5 ББСБ байгаагаас 2013 оны эхний хагас жилийн тайлант хугацаанд 1,656,119.6 мянган төгрөгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын өглөг бүртгэгдсэн.

2013 оны эхний хагас жилийн байдлаар хоёрдогч өглөгтэй 7 ББСБ байгаагаас тэдгээрт 1,822,633.2 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Хорооны 2010 оны 199 дүгээр тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас хаалттай өрийн бичиг гаргах журам”-ыг батлан мөрдөж эхэлсэн ба энэхүү журмыг 2012 оны 248 дугаар тогтоолоор хүчингүй болгож “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичиг бүртгэх журам”-ыг шинэчлэн баталж, мөн оны 346 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.

Хаалттай өрийн бичгийн зөвшөөрөлтэй 3 ББСБ нь /”Бизнес инвест девелопмент ББСБ” ХХК-д 800.0 сая төгрөг, “Хөгжил финанс ББСБ” ХХК-д 600.0 сая төгрөг, “Нэткапитал финанс корпораци ББСБ” ХХК-д 1,600.0 сая төгрөг/ нийт 3,000.0 сая төгрөгийн өрийн бичиг гаргахаар Хороонд бүртгүүлсэн боловч 2013 оны эхний хагас жилийн байдлаар ”Бизнес инвест девелопмент ББСБ” ХХК нь 376.0 сая төгрөгийн хаалттай өрийн бичгийг гаргаад байна.

## ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

2013 оны эхний хагас жилийн байдлаар 233 ББСБ нь нийт 12,963,238.7 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 55.9 хувиар өссөн, тайлант хугацаанд нийт орлого 27.2 хувиар, зардал 16.1 хувиар тус тус өссөн байна. Үүнд: /мянган төгрөгөөр/

/Хүснэгт 11/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.6.30	2013.6.30	Өөрчлөлт	
		Дүн	Дүн	Дүн	Хувь
1	НИЙТ ОРЛОГО	29,842,728.1	37,965,607.3	8,122,879.2	+27.2%
2	НИЙТ ЗАРДАЛ	21,526,082.0	25,002,368.6	3,476,286.6	+16.1%
3	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	8,316,646.1	12,963,238.7	4,646,592.6	+55.9%

Нийт орлого өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд: /мянган төгрөгөөр/

/Хүснэгт 12/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.6.30		2013.6.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	<b>ХҮҮГИЙН ОРЛОГО</b>	<b>20,205,815.2</b>	<b>67.7</b>	<b>29,332,018.0</b>	<b>77.3</b>	<b>9,126,202.8</b>	<b>45.2</b>
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	18,769,351.8	62.9	28,543,429.7	75.2	9,774,077.9	52.1
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	479,228.0	1.6	549,323.1	1.4	70,095.1	14.6
	Бусад хүүгийн орлого	957,235.3	3.2	239,265.2	0.6	-717,970.1	-75.0
2	<b>ХҮҮГИЙН БУС ОРЛОГО</b>	<b>8,790,415.1</b>	<b>29.5</b>	<b>8,039,990.3</b>	<b>21.2</b>	<b>-750,424.8</b>	<b>-8.5</b>
3	<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>843,026.7</b>	<b>2.8</b>	<b>565,089.0</b>	<b>1.5</b>	<b>-277,937.7</b>	<b>-33.0</b>
4	<b>ЕРДИЙН БУС ОРЛОГО</b>	<b>3,471.1</b>	<b>0</b>	<b>28,510.0</b>	<b>0.1</b>	<b>25,038.9</b>	<b>7.2 дахин</b>
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>29,842,728.1</b>	<b>100.0</b>	<b>37,965,607.3</b>	<b>100.0</b>	<b>8,122,879.2</b>	<b>27.2</b>

Тайлант хугацааны нийт орлогын 77.3 хувийг хүүгийн орлого /өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45.2 хувиар өссөн/, 21.2 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.5 хувиар буурсан/ эзэлж байна.

Хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар буурсан нь дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд: /мянган төгрөгөөр/

/Хүснэгт 13/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.6.30		2013.6.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	<b>Арилжааны орлого</b>	<b>2,600,222.40</b>	<b>29.6</b>	<b>1,632,588.30</b>	<b>20.3</b>	<b>-967,634.1</b>	<b>-37.2</b>
1.1	Гадаад валютын арилжааны орлого	2,150,218.30	24.5	1,632,309.80	20.3	-517,908.5	-24.1
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	450,004.10	5.1	278.5	0.0	-449,725.6	-99.9
2	<b>Ханш болон үнэлгээний тэгшигтгэлийн орлого</b>	<b>4,155,256.50</b>	<b>47.3</b>	<b>3,647,594.80</b>	<b>45.4</b>	<b>-507,661.7</b>	<b>-12.2</b>
2.1	Гадаад валютын ханшийн тэгшигтгэлийн орлого	4,155,256.50	47.3	3,392,335.50	42.2	-762,921.0	-18.4
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшигтгэлийн орлого	-	-	255,259.30	3.2	255,259.3	100.0
3	<b>Санхүүгийн үйлчилгээний орлого</b>	<b>2,034,936.20</b>	<b>23.1</b>	<b>2,759,807.20</b>	<b>34.3</b>	<b>724,871.0</b>	<b>35.6</b>
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	-	-	197	0.0	197.0	0.0
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	-	-	-	-	-	-
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	438,866.30	5.0	331,663.00	4.1	-107,203.3	-24.4
3.4	Картын үйлчилгээний орлого	-	-	-	-	-	-

3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	48,430.20	0.6	363,655.20	4.5	315,225.0	6.5 дахин
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	945,880.20	10.8	1,822,902.80	22.7	877,022.6	92.7
3.7	Бусад	601,759.50	6.8	241,389.30	3.0	-360,370.2	-59.9
	<b>ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ</b>	<b>8,790,415.10</b>	<b>100.0</b>	<b>8,039,990.30</b>	<b>100.0</b>	<b>-750,424.8</b>	<b>-8.5</b>

2012 оны эхний хагас жилийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 29.6 хувийг гадаад валютын арилжааны орлого, 47.3 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 23.1 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол 2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 20.3 хувийг гадаад валютын арилжааны орлого, 45.4 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 34.3 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого тус тус эзэлж байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна. Үүнд: /мянган төгрөгөөр/


/Хүснэгт 14/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.6.30		2013.6.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	2,961,672.10	13.8	3,975,634.90	15.9	1,013,962.80	34.2
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	15,711,409.10	73.0	17,441,152.10	69.8	1,729,743.00	11.0
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	1,245,727.90	5.8	1,574,192.60	6.3	328,464.70	26.4
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	556,047.50	2.6	429,050.30	1.7	-126,997.20	-22.8
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	4,107.70	0.0	2,516.10	0.0	-1,591.60	-38.7
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	1,047,117.70	4.9	1,579,822.70	6.3	532,705.00	50.9
	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>21,526,082.00</b>	<b>100.0</b>	<b>25,002,368.70</b>	<b>100.0</b>	<b>3,476,286.70</b>	<b>16.1</b>

2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт зардал өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар өссөнөөс хүүгийн зардал 34.2 хувиар, хүүгийн бус зардал 11.0 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 26.4 хувиар, орлогын татварын зардал 50.9 хувиар тус тус өсч, үндсэн бус үйл ажиллагааны болон ердийн бус зардал 22.8 - 38.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 9/



Тайлант хугацаанд 184 ББСБ буюу нийт ББСБ-ын 79.0 хувь нь ашигтай ажиллаж тэдгээрийн нийт ашиг 12,963,238.7 мянган төгрөгт хүрсэн байна.

**ЗУРГАА. БҮЛГИЙН САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 400,000.0 мянган төгрөг хүртэл активтай 400,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл активтай, 1,000,000.0 мянган төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай ББСБ гэсэн 3 бүлэгт хуваан тооцов.

2013 оны эхний хагас жилийн эцсийн байдлаарх бүлгүүдийн бүтэц дараах байдалтай байна:

/Хүснэгт 15/

№	Бүлэг	Бүлэгт хамаарах ББСБ-ын тоо	Бүлгийн нийт актив		Нэмэлт мэдээлэл
			Актив /мянган төгрөг/	Нийт активт эзлэх хэмжээ/хувь/	
1	Бүлэг 01	53	235,542,822.0	76.5%	1,000,000.0 мянган төгрөгөөс дээш хэмжээний активтай
2	Бүлэг 02	113	61,436,136.0	20.0%	400,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
3	Бүлэг 03	67	10,757,259.0	3.5%	400,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
<b>НИЙТ</b>		<b>233</b>	<b>307,736,217.0</b>	<b>100.0%</b>	

2013 оны эхний хагас жилийн байдлаарх бүлгүүдийн тайлант үеийн ашиг дараах байдалтай байна. Үүнд: /мянган төгрөгөөр/

/Хүснэгт 16/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Нийт актив	Хувьцаат капитал	Ашиг	Салбарын нийт татварын дараах цэвэр ашигт эзлэххувь
1	Бүлэг 01	235,542,822.0	97,700,822.1	10,584,854.2	81.7%
2	Бүлэг 02	61,436,136.0	52,937,336.1	2,368,057.5	18.3%
3	Бүлэг 03	10,757,259.0	10,346,695.4	10,327.0	0.1%
<b>НИЙТ</b>		<b>307,736,217.0</b>	<b>160,984,853.6</b>	<b>12,963,238.7</b>	<b>100.0%</b>

Бүлгүүдийн санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг харьцуулахад “Бүлэг 01”-д хамаарах 53 ББСБ нь нийт ББСБ-ын 22.7 хувийг, нийт активын 76.5 хувийг, хувьцаат капиталын 60.7 хувийг, тайлант хугацааны ашгийн 81.7 хувийг тус тус эзэлж байна.

**ДОЛОО. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Тайлант хугацаанд Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 189 ББСБ бүрэн хангаж ажилласан, 44 ББСБ 1-3 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй үзүүлэлттэй байгаагаас 1 харьцааг хангаж ажиллаагүй 19 ББСБ, 2 харьцааг хангаж ажиллаагүй 18 ББСБ, 3 харьцааг хангаж ажиллаагүй 7 ББСБ байна.

Санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 198,729,803.9 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 229,526,448.7 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын хувьд 85.6 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 91.2 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 63.8хувь;

- түргэн борлогдох актив 72,578,694.6 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 76,537,389.0 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 94.8 хувь;

- валютын дансны цэвэр зөрүү 11,999,190.9 мянган төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 198,729,803.9 мянган төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 6.04 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 17,852,496.9 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 198,729,803.9 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн харьцаа 8.98 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 4,088,317.9 мянган төгрөг, нийт актив 307,736,215.4 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.3 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 5,273,652.8 мянган төгрөгөөр байгуулбал зохицоо 42,463.2 мянган төгрөгөөр илүү буюу нийт 5,316,116.1 мянган төгрөгөөр байгуулсан байна.<sup>2</sup>

### НАЙМ. ДҮГНЭЛТ

1. Тайлант жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 233 ББСБ-аас 231 ББСБ /99.1 хувь/ тайлангаа ирүүлсэн ба 2 ББСБ /0.8 хувь/ өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс тайлангийн ирц сайжирсан байна.
2. Нийт 233 ББСБ-аас 14.2 хувь нь буюу 33 ББСБ нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрлүүдээс 3-4 төрлийн үйл ажиллагааг зэрэг эрхлэхээр тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа бөгөөд энэ хэмжээ төдийлөн нэмэгдэхгүй байгаа нь ББСБ-уудын хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө санхүүгийн чадвараас хамаарч үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх хандлага сул байна.
3. ББСБ-уудын голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 78,913,954.2 мянган төгрөг буюу 34.5 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 48,962,071.8 мянган төгрөг буюу 35.2 хувь, эзэмшигчдийн өмч 46,138,761.1 мянган төгрөг буюу 30.2 хувь, нийт дүрмийн сан 31,769,626.5 мянган төгрөг буюу 24.6 хувиар тус тус өссөн байна.
4. ББСБ-уудын нийт актив 2013 оны эхний хагас жилийн байдлаар 307,736,217.0 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын */банкны салбарын нийт актив 15,940,911,126.8 сая төгрөг/ 1.9 хувь*, нийт зээлийн өрийн үлдэгдэл 188,120,936.3 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлийн */банкны салбарын нийт зээл 8,652,327,087.7 мянган төгрөг/ 2.2 хувь*, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 7,158,193.6 мянган төгрөг байгаа нь банкны салбарын чанаргүй зээлийн */банкны салбарын чанаргүй зээл 315,222,153.2 мянган төгрөг/ 2.3 хувь*, нийт дүрмийн сан 160,984,853.6 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт дүрмийн сангийн */банкны салбарын нийт дүрмийн сан 357,908,947.4 мянган төгрөг/ 45.0 хувь*тай тус тус тэнцэж байна.
5. Тайлант хугацаанд 1 дүгээр бүлгийн буюу 1,0 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй 53 ББСБ байгаа ба тэдгээрийн нийт актив 235.5 тэрбум төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын активын 76.5 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 10 ББСБ-ын 66.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.
6. 2013 онд Хороонд төвлөрүүлбэл зохих нийт 212 ББСБ-ын 208,055.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөгдөхөөс 2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт 204 ББСБ-ын 203,850.0 мянган төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд төвлөрүүлсэн нь 98.0 хувьтай байна.
7. Зээлийн мэдээллийн тухай хууль 2011 оны 10 дугаар 20-ны өдөр батлагдан гарснаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар зөвшөөрсөн байгууллага зээлийн мэдээллийн сантай байхаар хуульчилсны дагуу тайлант хугацаанд нийт 83 ББСБ Монголбанкны зээлийн мэдээллийн

<sup>2</sup>Энэхүү тоон үзүүлэлтийг гаргахдаа тухайн ББСБ-уудын ТОП20 зээлдэгчийн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно.



сантай хамтран ажиллах гэрээ байгуулан, зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглаж байгаа нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх 191 ББСБ-ын 43.4 хувийг, нийт 233 ББСБ-ын 35.6 хувийг тус тус эзэлж байна.

